

МӨНГӨНИЙ ЗӨВ ХЭРЭГЛЭЭ БА ХАДГАЛАЛТЫН СОЁЛ

Биднийг төрөхөөс өмнө бий болж бүх цаг үед арилжааны гол хэрэгсэл болсоор ирсэн мөнгө, төрсөн цагаас минь бидэнд төлөвшсөн мөн чанар хоёр энэ амьдралд зохицож, эсвэл зөрчилдөж байдаг. Тэгвэл мөнгө гэж юу вэ? Мөнгө бол жирийн нэг Сүхбаатар жанжин, Чингис хааны зурагтай олон өнгөт цаас биш юм. Мөнгө бол хүн төрөлхтний бүтээсэн хамгийн чухал хэрэглүүрийн нэг билээ. Энэ нь зөвхөн хэрэгсэл төдийгүй эдийн засгийн тогтвортой байдал, хувь хүний амьдралын чанарт нөлөөлдөг чухал хүчин зүйл юм. Гэхдээ мөнгийг хэрхэн зөв зохистой ашиглах, хадгалах талаарх ойлголт, дадал нь бидний санхүүгийн ирээдүйд хамгийн чухал үүрэг гүйцэтгэнэ. Энэхүү эсээнд мөнгөний зөв хэрэглээ, хадгалалтын ач холбогдол, зөв дадлыг хэрхэн бий болгох, түүний үр шимийн талаар өгүүлэх болно.

Мөнгөний зөв хэрэглээ гэдэг нь орлогоо хэрэгцээтэй зүйлд зарцуулах, үргүй зардлаас зайлсхийх, мөнгөө оновчтой хуваарилах чадвар юм. Зөв хэрэглээ нь зөвхөн санхүүгийн сайн байдалд нөлөөлөх төдийгүй, хувь хүний амьдралын чанар, сэтгэл ханамжид эерэг нөлөө үзүүлдэг. Тухайлбал, мөнгөний зөв хэрэглээтэй хүн өөрийн өдөр тутмын хэрэгцээгээ хангаж, үлдсэн орлогоо хуримтлалд шилжүүлснээр санхүүгийн тогтвортой байдлаа хангадаг. Үүний үр дүнд гэнэтийн санхүүгийн хямралд орох эрсдэл буурч, ирээдүйн зорилгодоо хүрэх боломж нэмэгдэнэ.

Мөнгөний хадгалалтын соёл гэдэг нь хүмүүсийн мөнгөө зөв зохистой хадгалах, хуримтлуулах, ирээдүйд зориулан санхүүгийн нөөц бүрдүүлэхтэй холбоотой дадал зуршил, ухамсартай хандлагыг хэлнэ.

Монгол улсын иргэдийн мөнгөний хэрэглээг авч үзэхэд зарим хүмүүсийн санхүүгийн боловсрол дутмаг, төлөвлөлтгүй хэрэглээ, богино хугацааны ашиг сонирхлыг илүүд үздэг хандлагаас үүдэлтэй алдаанууд давамгайлж байна.

Эдгээрээс хамгийн их асуудал дагуулдаг нь мөрийтэй тоглоом, өрийн дарамт, үр ашиггүй зээл зэрэг сөрөг үзэгдлүүд юм. Мөрийтэй тоглоом нь богино хугацаанд их хэмжээний мөнгө олох боломжтой мэт харагддаг ч, үнэн хэрэгтээ олон хүний санхүүгийн хямралд хүргэдэг. Мөрийтэй тоглоом зохион байгуулдаг агентаар дамжин 2024 онд 500 сая ам.доллар, 2025 он гарснаас хойш эхний 2 сарын байдлаар 87 сая ам.доллар Монгол улсаас гарчээ. Мөрийтэй тоглоом нь хүмүүс бүх орлогоо алддаг төдийгүй, өрөнд орж, зээл авахад хүрдэг. Угаас монголчууд зээл авах хандлага ихтэй учир зээлийг ашиглахдаа зохистой төлөвлөлт хийдэггүй. Насанд хүрсэн иргэдийн 70 гаруй хувь нь буюу 1.8 сая иргэн аппликэйшны зээлтэй байна.

Эдгээр иргэдийн нийт зээлийн хэмжээ 3.7 их наяд төгрөг байгаа юм. Зүйрлэж үзвэл, банк бус санхүүгийн байгууллагуудын иргэдэд олгосон зээлийн мөнгөн дүн манай улсын нийт төсвийн 15 орчим хувийг эзлэхүйц өндөр дүнд хүрсэн байна. Нэг иргэн багадаа 2-3 аппликэйшн ашигладаг бөгөөд нэг аппликэйшнээс дунджаар 500 мянгаас 1 сая хүртэлх төгрөгийн зээл авдаг. Зээлээ хугацаанд нь төлж чадахгүй байх тохиолдол ч элбэг. Энэ нь хүүгийн дарамтыг нэмэгдүүлж цаашдын санхүүгийн байдалд сөргөөр нөлөөлнө. Орлогоосоо давсан зээл авснаар нэг зээлээр нөгөө зээлээ даран өрийн гинжин дарамтад ордог. Иргэд судлалгүйгээр яаран өндөр хүүтэй зээл авч, хэрэглээний зээл, ухаалаг утас, машин гэх мэт хэрэгцээгүй эсвэл хэт үнэтэй зүйлсэд мөнгөө үрэх явдал түгээмэл тохиолдоно. Удаан хугацааны зорилгоо үл хайхарч, түр зуурын аз жаргалд мөнгөө зарцуулах нь хөрөнгө хуримтлуулах боломжийг бууруулдаг. Санхүүгийн мэдлэгтэй хүмүүс орлого, зарлагаа хянах, өр, зээлийг зөв ашиглах, мөнгөө хуримтлуулах талаар илүү үр дүнтэй шийдвэр гаргадаг бол үүний эсрэг хүмүүс санхүүгийн алдаа гаргах магадлалтай.

Монголчуудын хувьд хуримтлал үүсгэх соёл сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа ч, энэ тал дээр тодорхой сул талууд, алдаатай хандлагууд ажиглагддаг. Үүнд хүмүүсийн хуримтлалын талаарх буруу ойлголт нөлөөлнө. Хуримтлал гэж юу вэ? Хуримтлал гэдэг нь хүн өөрийн орлогоос тодорхой хэсгийг хадгалж, ирээдүйд ашиглах зорилгоор хуримтлуулсан хөрөнгө юм. Энэ нь мөнгөн хэлбэрээр төдийгүй, үнэт цаас, хөрөнгө оруулалт, эсвэл бусад хэлбэрээр ч байж болно.

Мөнгөө хадгалж, хуримтлуулснаар санхүүгийн хараат бус байдал бий болгох, ирээдүйн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох, ирээдүйд учирч болох гэнэтийн эрсдэлээс хамгаалах, сэтгэл зүйн тайван байдлыг бий болгох зэрэг олон давуу талтай юм. Энгийнээр хэлбэл, хуримтлал бол санхүүгийн хувьд өөртөө баталгаа гаргаж буй нэг төрлийн хөрөнгө оруулалт юм.

Хүмүүсийн дийлэнх нь хуримтлал үүсгэх шаардлагатайг ойлгодог боловч “Дараа хийж болно” гэсэн бодолтойгоор одоогийн орлого зарлагаа хянахгүйгээр хойшлуулах нь түгээмэл. Энэ нь хуримтлал үүсгэх, эхлэх хугацааг үргэлж хойшлуулдаг. Түүнчлэн “Их хэмжээний, хангалттай мөнгөтэй болохоороо хуримтлал үүсгэнэ” гэдэг. Орлого бага байгаа үед хуримтлал хийх боломжгүй гэж үздэг ч, бага хэмжээний ч гэсэн хуримтлал үүсгэж эхэлснээр санхүүгийн сахилга бат нэмэгдэнэ. Жишээлбэл хуримтлал үүсгэж хадгаламж нээх талаар хүмүүс ихэвчлэн их мөнгө бөөнөөр хадгалах эсвэл “Хэрэглээнд байгаа мөнгө маань хүрэхгүй байхад юун илүүчлэх” гэж боддог аж.

Банкинд ажилладаг танил маань /борлуулалтын ажилтан/ харилцагч нартаа хуримтлалыг хэрхэн санал болгодог талаараа мэдлэгээ хуваалцсан юм. Банкаар үйлчлүүлж байгаа харилцагч нараасаа “Та хадгаламж нээх үү” гэж асуухад бүгд үгүй гэж хариулдаг байна. Харин “Та сар бүрийн цалин дээрээсээ 5000 юм уу 10000 төгрөг автоматаар татахаар хуримтлал үүсгэх үү” гэж асуухад үгүй гэж хэлэх хүн ховор байдаг бөгөөд ихэнх нь сард 1-2 удаа 10000-20000 төгрөг

хуримтлуулахаар хадгаламж нээлгэдэг гэсэн юм. Мөн өндөр настай иргэдэд “Хөнгөлөлттэй амралтад 10 хоног 100.000 төгрөгөөр амардаг шүү дээ та түүнийгээ хуримтлалаар сард 10000 тэтгэврээсээ хуримтлуулах уу ?” гэхэд дуртай хүлээж авдаг гэнэ. Хүмүүс хуримтлалыг зүгээр л мөнгө хураах гэж ойлгодог ч тодорхой зорилго тавьдаггүй. Зорилгогүй хуримтлал нь хүмүүсийн хуримтлуулах идэвхийг бууруулж, хэтэвчнээс мөнгөө буруу ойлголттойгоор зарцуулахад хүргэдэг.

Хуримтлалын гайхамшгийг нотлох жишээ дурдвал дэлгүүрийн цэвэрлэгч Роналд Рийд нас барахдаа 6 сая долларыг сайн үйлст хандивлаж олныг шуугиулсан явдал юм. Тарчиг амьдралтай, уранхай жинстэй, бага цалинтай эр хэрхэн ийм их мөнгө хуримтлуулж чадсан нь санхүүчдийн анхаарлыг зүй ёсоор татав. Америкийн Вермонт мужид ядуу айлд мэндэлсэн Роналд гэр бүл дотроосоо анхны дунд сургууль төгссөн хүн болжээ. Сургуулиа төгсөөд армид алба хаасны дараа эргэж ирээд амьдралынхаа туршид шатахуун түгээгч, механикч, цэвэрлэгч зэрэг ажил хийсэн байна. Тэрээр нас барахдаа нийт 8 сая долларын хөрөнгө үлдээсэн бөгөөд үүний ихэнх нь хувьцаанд хийсэн хөрөнгө оруулалт хэлбэрээр байсан аж. Роналд маш эртнээс сар бүрийн цалингаасаа багахан мөнгөөр хувьцаа авч эхэлжээ.

Үүгээр ч зогсохгүй тэрээр хувьцаанаас жил бүр авах өгөөжөөр дахин хөрөнгө оруулалт хийж байв. Ингээд дуслыг хураавал далай гэдэг зарчмаар цэвэрлэгчийн цалингаар 8 сая долларын хөрөнгийг босгож чадсан байна. Энэ түүхээс бид мөнгөний зөв хэрэглээ, хадгалалтын соёл нь хувь хүний санхүүгийн тогтвортой байдалд чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь зөвхөн санхүүгийн асуудлыг шийдвэрлэх төдийгүй хувь хүний ирээдүйг тодорхойлох суурь болно. Зөв төлөвлөлт, санхүүгийн сахилга баттай байх, боловсролдоо анхаарах нь эдгээр

дадлыг амжилттай хэрэгжүүлэх гол түлхүүр юм. Тиймээс бид мөнгөө зөв удирдан, ирээдүйдээ итгэлтэйгээр алхах хэрэгтэй гэдгийг харж болно.

Хэрхэн мөнгөний зөв хэрэглээг бий болгох вэ? Хувь хүний зүгээс эхлээд санхүүгийн зорилгоо тодорхойлох. Дараа нь төсөв гарган орлого болон зардлаа нарийвчлан тэмдэглэж, хянана. Зардлуудаа хэрэгцээт, шаардлагатай гэх мэт ангилах, орлогынхоо тодорхой хэсгийг /жишээ нь 20%/ хуримтлалд оруулна. Үүний дараагаар хэрэггүй зардлаа багасгаж, орлогоо нэмэгдүүлэх арга зам хайна. Эцэст нь өр зээлийн хэмжээг тогтмол бууруулж, боломжтой бол хүү багатай, ашигтай нөхцөлтэй зээлийг сонгоорой. Тэвчээртэй, санхүүгийн сахилга баттай байж чадвал та санхүүгийн тогтвортой байдалд хүрч чадна.

Харин арилжааны банкууд болон төв банк, төр засгийн зүгээс иргэддээ ээлтэй, уян хатан зээлийг санал болгож, цахим орчин, интернэт, телевизийн зар сурталчилгаагаар хүүгүй, орлого нотлох шаардлагагүй, урьдчилгаа хэрэггүй гэх мэтчилэн олон төрлийн зээлийг сурталчилдаг шиг хуримтлалын хөтөлбөрүүд, хугацаатай хадгаламж, хувьцаа, бондыг сурталчилж хүмүүст үр ашгийг нь таниулах хэрэгтэй. Жишээ нь Голомт банкны зүгээс хэрэгжүүлсэн "Үндэсний хуримтлалын хөтөлбөр" хэрэгжсэнээр 7 сарын хугацаанд 29 мянга гаруй харилцагч үндэсний хуримтлалтай болсон үр дүнг үзүүлжээ.

ААН, төрийн байгууллагуудын зүгээс дотоод зохион байгуулалтдаа өөрчлөлт хийн ажилчдынхаа цалинг хуримтлуулж ч болох юм. Жишээ нь Хаан банк нь ажилчдынхаа цалингийн 0.02 хувийг хуримтлуулдаг байна. Тухайн ажилтан нь хүссэн цагтаа хадгаламжаа цуцлан өөрийн хуримтлуулсан мөнгөө авах боломжтой юм. Өөр нэгэн шийдэл бол зөвхөн насанд хүрэгчдээс гадна хүүхдүүдэд ч бас мөнгөө хуримтлуулах, хадгалах боломж, нөхцөлийг нь бүрдүүлж, технологитой хоршуулан хязгаар нь үл харагдах "CANDY CRUSH" тоглоомын үе шиг бага багаар шат ахин мөнгө хуримтлуулан, санхүүгийн

боловсрол эзэмших боломжтой апп бүтээж болох юм. Мөн “MIND RUSH” асуулт хариултын тэмцээн шиг ангиараа, гэр бүлээрээ, найз нөхдөөрөө хуримтлал үүсгэн оролцох боломжтой уралдаан, тэмцээн, хөтөлбөр зохион байгуулж болно.

Эцэст нь хүн "Мөнгийг захиран, хүссэнээрээ зарцуулж амьдрах уу?" эсвэл "Мөнгөнд захирагдан, хүслээ мөнгөөр хязгаарлуулах уу?" гэдэг өөр хэнээс ч бус танаас л хамаарна. "Мөнгө бол цаас юм" хэмээн олон хүн бодож хандах авч, нэг л мэдэх дор түүний төлөө амьдраад ч байгаа юм шиг хэмнэлдээ гайхан зогтосдаг. Заримдаа хар тамхи шиг түүнд донтож, түүний төлөө юуг ч хамаагүй хийж, амьдралын хамаг үнэ цэнэтэй бүхнээ мөнгөөр арилжиж дуусаад харамсаж суух үе ч байдаг. Иймд бид хүүхдүүдээ багаас мөнгөтэй харьцах арга, ухаан, санхүүгийн боловсролд сургаж, өөрсдөө ч санхүүгийн мэдлэг, хадгалах соёлтой байх хэрэгтэй юм.

**Өмнөговь аймгийн Даланзадгад сумын
Ерөнхий боловсролын 3-р сургуулийн
12в ангийн сурагч Б.Тэргэлсаран**